



ДУНДГОВЬ АЙМАГ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТ**

## АГУУЛГА

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго .....	3
Хоёр. Хяналт шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй.....	3
Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.....	4-25
Дөрөв. Дүгнэлт .....	26-30
Дөрөв. Санал, зөвлөмж .....	30-31

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 01 сарын 30

Мандалговь хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэгдсэн тухайн оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшнийг тусгагдсан зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, удаашралтай хэрэгжиж байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасан арга зүйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ирүүлсэн тайлангаас гадна иргэдэд ил тод мэдээлсэн мэдээлэл, газар дээр нь очиж танилцах, нотлох баримтад үндэслэх, статистик мэдээлэлтэй тулган үзэж зэргээр мэдээллийг баталгаажуулж, үнэлгээ хийсэн болно.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээг зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр буюу журмын 6.2.3-т заасан арга зүйг ашиглаж тооцлоо.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дараах ажлуудыг гүйцэтгэж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 20 хэлтэс, агентлагууд, сумдад 2023 оны 5 сард удирдамжийн дагуу зохион байгуулж, зөвлөн тусалж ажиллалаа.

Явцын хяналт шинжилгээг 5,9,10,11 саруудад хийж, зөвлөмжийн мөрөөр ажил сайжруулах “Сонсгол, мэдээлэл” арга хэмжээг төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг удаашралтай хэрэгжүүлж байгаа 7 агентлагийг оролцуулан удирдлагын хурлаар хэлэлцүүлэн ажил эрчимжүүлэх чиглэлийг өгч ажилласан.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар

2023.11.03 · 🌐

...

### СОНСГОЛ МЭДЭЭЛЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн удаашралтай хэрэгжиж буй заалт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг хэлэлцэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх, бодлогын хэлтэс, агентлаг хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс зохион байгуулж, аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат болон хэлтэс, аг... Цааш үзэх



Мөн аймгийн Засаг дарга 2023 оны 11 сард аймгийн 300 гаруй иргэдэд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан тавьж, санал бодлыг сонсон, хэлэлцүүлэг өрнүүлж, 15 сумын 6600 иргэдтэй уулзах уулзалтаар тайлан хэлэлцүүлэг зохион байгууллаа.



БОЛОВСРОЛЫН  
ЧАНАР ХҮРТЭЭМНИЙГ  
ДЭМЖИХ ЖИЛ  
2023



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТУХАЙ

**ИЛТГЭГЧ: Ц.МӨНХБАТ**  
Дундговь аймгийн Засаг дарга

2023

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд “Говийн хөгжил наран” төрийн бус байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэж, үнэлгээнд насанд хүрсэн 30578 иргэдийн 2,8% буюу 855 иргэнийг хамруулсан байна.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН,  
ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ ТОДОРХОЙЛОХ  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН  
2023 он

ГҮЙЦЭТГЭСЭН: Д.Атлангоос  
Э.Мөнхсүрэн

2023 он



Сум, агентлагийн удирдлагуудын “Удирдах ажилтны зөвлөгөөн” зохион байгуулж, 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр тэргүүлсэн сум, байгууллагын ажлын “САЙН ТУРШЛАГА” илтгэл танилцуулах ажлыг зохион байгууллаа.



Дундговь аймаг Засаг даргын Тамгын газар

2023.10.30 · 🌐

...

2022 ОНЫ ТЭРГҮҮНИЙ СУМ, БАЙГУУЛЛАГУУД САЙН ТУРШЛАГААСАА ХУВААЛЦЛАА

"Удирдлагын манлайлал-2023" сургалт зөвлөгөөний үеэр 2022 оны ажлаараа тэргүүлсэн сум, байгууллагын сайн туршлагыг нэвтрүүлэх, шинэ санаачилгыг дэмжих, бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор тэргүүний сум, байгууллагын удирдлагууд илтгэл мэдээлэл хийлээ.

Эрдэнэдалай сум 2022 оны ажлаараа шилдэг сумаар шалгарсан бөгөөд тус сумын Засаг дарга Б.Лхагвамандал боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжин ерөнхий боло... Цааш үзэх




Энэ онд Төлөвлөлт ба тайлагналтад анхаарах асуудал сэдвээр нийтдээ 6 удаа 422 албан хаагчид сургалт зохион байгуулсан байна.



Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн.

Иргэдийн хурлын төлөөлөгчид төлөвлөгөөний хэрэгжилтийн явцтай танилцан “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлэлт дүгнэлтийг өгсөн.



Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд бүтээн байгуулалт хийх 16 арга хэмжээ, үйлдвэр цех байгуулах 6 арга хэмжээ, уралдаан тэмцээн, олон нийтийг соён гэгээрүүлэх 10 арга хэмжээ, иргэд, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн 34 арга хэмжээ, иргэдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын шинжтэй 57 арга хэмжээ, сум, байгууллагуудыг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах 29 арга хэмжээ, хөрөнгө оруулалт татахад чиглэсэн 7 арга хэмжээ, цахим хөгжилтэй холбоотой 3 арга хэмжээ, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг бууруулахад чиглэсэн 17 арга хэмжээ, дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн 6 арга хэмжээ, хөдөө аж ахуй болон бусад чиглэлээр 12 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлсэн байна.



Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээнүүдээс иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа 57- байгаагаас иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, хүний хөгжил рүү чиглэсэн уулзалт, сургалт, амьдрах орчныг

сайжруулах агуулга бүхий 29 арга хэмжээ төлөвлөгдсөн нь 51 хувийг эзэлж байна. Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 48 зорилт, 197 арга хэмжээний дундаж 93.5 хувьтай байгаа нь өмнөх жилийн хэрэгжилтээс 0.8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		197
Үр дүнтэй	100%	171
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	3
	70%	7
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	5
	30%	5
Үр дүнгүй	0%	4
(Хүрсэн түвшин - Суурь түвшин) / (Зорилтот түвшин - Суурь түвшин) * 100	100>...>90	
	90>...>70	2
Хэрэгжилтийн дундаж		93,5%

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг 6 бодлогын хүрээнд зорилтыг үнэлж үзэхэд 93,5 хувийн хэрэгжилттэй байна.


№	Агуулга	Зорилтын тоо	Зорилтын биелэлт	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний биелэлт
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	100	6	100
2	Хүний хөгжлийн бодлого	19	95,2	81	95,1
3	Эдийн засгийн бодлого	11	98	51	90,8
4	Засаглалын бодлого	9	98	34	94,3
5	Ногоон хөгжлийн бодлого	6	83,3	17	95,9
6	Орон нутгийн хөгжлийн бодлого	2	85	9	72,2
<b>Дүн</b>		<b>48</b>	<b>92,7</b>	<b>198</b>	<b>93,5</b>

Аймгийн 15 сум, 23 агентлагийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тооцож ажилласнаар тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилт эхний хагас жилээс 15,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.






### ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХАРЬЦУУЛАЛТ



### 2023 ОНД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:

#### 1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2022 онд 83 хувьтай байсныг 2023 онд 85,8 хувьд хүргэлээ.



## 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Дундговь аймгийн хүний хөгжлийн индекс 2022 оны байдлаар 0.713 байгаа нь өмнөх оноос 0,006 индексээр өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хүн амын дундаж наслалт 74.7 байна. Энэ нь улсын дунджаас 3,4 насаар илүү ба улсад эхний 3-т эрэмбэлэгдэж байна.

2022 онд эрэгтэй хүний дундаж наслалт 70,9, эмэгтэй хүний дундаж наслалт 80 болж дундаж наслалтын зөрүү 9,1 байна.



Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэгт артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж -2, хөх, умайн хүзүүний өмөнгийн үзлэгүүдийг хийснээр 2022 онд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь 62,8 хувьтай байсан бол 2023 онд 87,5 хувьтай болж 24,7 хувиар өссөн байна.



Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн барилгын хангалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох ажлыг зохион байгууллаа.



### БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2022 онд 26649 байсныг 2023 онд 30538-д хүргэлээ.



## БОЛОВСРОЛ

Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2022 онд 42 хувь байсныг 2023 онд 47 хувьд хүргэхээр зорьсноос 51,3 хувьд хүрсэн байна.



Сургууль бүрд байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах ажлыг хэрэгжүүллээ.

2022 онд 11 кабинеттай байсан бол энэ хичээлийн жилд байгалийн ухааны 5 кабинетыг гэрчилгээжүүлээд байна. Эрдэнэдалай сум Мобиком корпорацийн “SMART EDUCATION 3” төслийн хүрээнд “Тэгш хүртээмжтэй боловсролыг хүүхэд бүрд хүргэх” зорилготой байгалийн ухааны 120 сая төгрөгийн өртөгтэй Дижитал ангитай боллоо.



**"Дундговь-боловсролын чанар" төсөл хэрэгжүүлж ажиллалаа.**

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр захирамжаар "Боловсролын чанар хүртээмжийг дэмжих жил" болгон зарлан "Дундговь-боловсролын чанар" төслийг аймгийн ИТХ-ын 2022 оны 61 дүгээр тогтоолоор 300,0 сая төгрөгийн санхүүжилт баталж, хэрэгжүүлэн төслийн хэрэгжилт 88,7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэв.



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

Байнгын ажлын байранд **623**, түр ажлын байранд **847** иргэнийг зуучилж нийт **1470** иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдсан байна.



## СОЁЛ, УРЛАГ

Соёл, урлагийн байгууллагууд монгол өв соёл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, урлаг уран бүтээлийн чиглэлээр нийт 43611 арга хэмжээ, сургалт сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор арга хэмжээнд 370823 иргэн хамрагдлаа.

### УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН" УРТЫН ДУУ, МОРИН ХУУРЧДЫН ИХ НААДМЫГ 47000 ХҮН ҮЗЭЖ СОНИРХЛОО

“Уяхан замбуу тивийн наран” уртын дууч, морин хуурчдын их наадмыг байгалийн задгай театрт зохион байгуулж, нутгийн 55-аас дээш насны ахмад 1176, хүүхэд 706, 19-54 насны авьяастан 1218 нийтдээ 3100 авьяастныг сургаж, хамрууллаа. Улсын хэмжээнд хамгийн олон үзэгчтэй наадмаар тодорхойлогдож, 47 мянган иргэнд нутгийн үнэт өв соёлыг түгээн сурталчилж чадлаа.



**БОЛОВСРОЛЫН ЧАНАР ХҮРТЭМЖИЙГ**

## СОЁЛ, УРЛАГ

**ДУНДГОВЬ ХӨГЖИНӨ**

**Эрдэнэтийн сум**  
Соёлын төв  
УТХС-2,3 тэрбум

- Нийт 7 барилга. Шинэ барилгын гүйцэтгэл 89.3 хувь (УТ 6,9 тэрбум, ОНХ 270.0 сая. төг)
- Аянга хамтлагт хөгжим, тэнгэр төхөөрөмж 74.0 сая төгрөг (Ихий гавь төсөл)
- ТХДЖТ-т дэлгэц 46,8 сая, ТТХТ-т дууны студи -50,0 сая, Музейд виртуаль тэнгэр төхөөрөмж 96,6 сая (Их соёл-эх үндэс төсөл)
- Улсын "Жижиг сум" Хүлд суманд тэнгэр төхөөрөмж УТ-115,0 сая, ОНХС-20 сая
- Барилга, тэнгэр төхөөрөмж УТ 7,3 тэрбум, ОНХ 390,0 сая төгрөг

Соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд хамрагдсан иргэн	2021	2022	2023
	348050	339784	326189

- 2022 онд салбарын 19 албан хаагчийн мэргэжлээ өргөжүүлж дээшлүүлэх сургалтын төлбөр, суралцах хугацааны дамжлага 20,8 сая төгрөг,
- Шилдэг төрийн албан хаагч 2 сая,
- 2023 онд Консерваторид суралцах 5 хүүхдэд 3,3 сая төгрөг.
- Салбарын 2 уран бүтээлчид орон байрны дамжлага-20,0 сая төгрөг Нийт 48,1 сая төгрөг

**Зорилго:**  
Иргэдийг соён гэгээрүүлэх, монгол өв соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо 2022 онд 313014 байсныг 2023 онд 322294 болгохоос 370823-т хүргэж үйлчиллээ.

**УЯХАН ЗАМБУУ ТИВИЙН НАРАН" УРТЫН ДУУ, МОРИН ХУУРЧДЫН ИХ НААДАМ**

"НҮДЭЛЧИН ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ" 2022-2023

**"ГОВИЙН ХҮҮДҮҮД" УРЛАГИЙН НААДАМ**

"ДУНДГОВЬ АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ ТУХАТ 99 ЖИБИЙН ОЙН УРЛАГИЙН ТОГЛОЛТ"

**"СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ" "СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023" "ДУНДГОВЬ-ДУУ ХҮҮР"**

**"ОЛОН УЛСЫН НААДАМ, ГАДААД ХАРИЛЦАА"**

Соёл, урлагийн 2298 үйл ажиллагаа зохион байгуулахаас 2430 соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, 2021-2023 онд давхардсан тоогоор нийт 1014023 иргэнийг хамруулжээ. УТ 623,7сая төгрөг, ОНТ 151,6 сая төгрөг


ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## Эдийн засгийн бодлогын хүрээнд


2022 оны аймгийн ДНБ оны үнээр урьдчилсан гүйцэтгэлээр 414934.548 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1.4 хувиар буюу 5,6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Улс болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 107-674 хувиар биелүүлснээр гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээний үүргийн биелэлтийг ханган 2023 онд төлөх төлбөр 3001,6 сая төгрөгийг улсын төсөвт 100 хувь төлж барагдуулсан.

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 674 хувиар биелүүлсэн нь ААН орлогын албан татварын 40 хувийг орон нутгийн төсөвт хуваарилдаг болсон, мөн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой.



2023 онд үүссэн газрын төлбөрийн орлого 556.75 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,303.37 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба өмнөх оноос 774.18 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Орлого бүрдүүлэлт 234 хувийн гүйцэтгэлтэй гарсан ба урьд онтой харьцуулахад 95 хувиар ахисан байна.





**ТӨРИЙН САНГИЙН УДИРДЛАГЫН ЦАХИМ СИСТЕМ БОЛОН САНХҮҮГИЙН ПРОГРАММ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ**





**ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦОО**

Төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах зорилтын хүрээнд төрийн хуулийн этгээд 139, хуулийн этгээдийн эрхгүй 31 нийт 170 байгууллагыг цахимд шилжүүлж төлбөр тооцооны 98,6 хувийг цахимжууллаа.



**ПРОГРАММ ХАНГАМЖ**

Нийт 44 байгууллагын албан хаагчдын компьютер техник хэрэгсэл, орон нутгийн төсвийн байгууллагуудын НББ-ийн программ, төрийн сангийн програмыг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаас 630.0 сая төгрөгийн 107 тоног төхөөрөмжийн шинэчлэл сайжруулалт хийлээ.



**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

Төрийн сангийн удирдлагын цахим системийн шинэчлэлтэй холбоотойгоор нягтлан бодогчид, төрийн сангийн албан хаагчдад 3 төрлийн санхүүгийн программу шинэчлэлтийг 75 байгууллагад хийж, чадавжуулах сургалтуудыг зохион байгууллаа.










ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

“Монгол Улсад ил тод байдал, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” буюу MASAM II төслийн хүрээнд хэрэгсэл ашиглан ХОХБТ Хэлтэстэй хамтран аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдсан төсвийн мэдээллийг ашиглан “Иргэдийн төсөв-2023 эмхэтгэл” 500 ширхгийг боловсруулан Дэлхийн банкны төслийн ажилтнаар хянуулан баталгаажуулж, иргэдийг мэдээллээр хангалаа. Мөн цахим ном (online flip) хэлбэрээр гаргаж, dundgovi.gov.mn, dundgovi.khural.mn, montsame.mn сайт Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар, Гэрэлтдэг ертөнц фейсбүүк хуудаст байршуулан 24 удаа дамжуулан цахим орчинд түгээсэн байна.



**ИРГЭДИЙН ТӨСӨВ**

2023 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАВ





Дундговь аймаг "ИРГЭДИЙН ТӨСӨВ - 2023"



**МЭНДЭГЦЛЭЭ**

Умар өдөр байгаа 2023 он Дуг зуур өө соёлын нутга Дундговь аймаг угсан байгуулагданы түүт 20 жилийн ой, Нутгийн удирдлагын цэмо тэтгэцээр түүт ажигноор 20 жилийн ой дэмжсэн, Бүтэн байгуулалт, ажлын шигшлийн үндэстэн иргэдийн өдөр, урам зориг зорж ажлын хийгээдээр манайнхад цаг ямар ч талтай өвөл, амаарта өнтэй, улам мунор нь хэр бөргөрт сайхан жил байлаа.

Аймгийн эдний засгийн хөгжилд амьд дийцэлт гарч аймгийн төв, сумдад нийгэм, соёл, ах аруйн зориулалттай өлөн баянга байгууламжууд ажиллагаадад орж, хэдий лэдэн сумын төсвийн мөнгөний төлөвлөлтөнд хийгээд зоргоолуудыг ижилчлэн орсон, манай ноёрхлын чөлөөн түлээн хийн сургаа 3.5 саягаар дугуулан өслөг ашиг харууларийн улс, аймгийн ажрга манам өрн өлсөөр тодорч, тэд хөдөлмөр бүтээхэд төв засагт мануусын байлаа.

2023 оныг "Түүнэй илгээлийг дэмжсэн жил" болгосон хэрэгдэ түүнэй нөсөөийг залуучууд манлайр хэрэгжүүлсээр эрүүл мэнд, боловсрол, нэрөө ах аруу сайбар дэлч үүний нөсөөийг дугуудалт зөний хөгжилд дийцэх, түүний ажлаах, суун боловсрол, мөдөг, мэргэжлээ агуулах, зүүн мэнд, орон сууни төлөвлөг сайжруулахад 260 саяга төгрөгөөр амьсгаа зарцуулаа.

Төсвийн ил тод, харуулагатай байдалд дэхиулууд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь төр иргэдийн оролцод баг бай түүншлэ бай болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Татвар төлөгч иргэн тэний болон ах аруйн нөсөө байгууламжууд харууларийн үр шимээс бэрлэж байгаа төсвийн чөлөө нөсөөд зарцуулж буй амьдр үр дүнд хүрэн таларал нээлтэйг мэрдэлсэн хэр иргэдийн төсөө боловсруулах үйл ажил дэлч оролцоог нэмэгдүүлэн цаашаа, төлөвн таларал хүрэн зарцуулж буйг үнэтэнт тэний болонг болгохын өмнө 2023 оны батлагдсан төсвийн мэдээллийг "Иргэдийн төсөв-2023" эмхэтгэлийг батлагдсана бүтээхэд хүргэж байна. Төсөө боловсрууланы үйл ажилд иргэдийн оролцоог манам, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хамт орохын зоргоон амьсгаа эмхэтгэлийг санхүүгийн боловсруулж буй Дундговь банкны "Монгол улсад нийгмийн эгэх харуудлалыг болжуулах нь" буюу MASAM II төслийн багт өмнөд таларал харуулаа.

Та бүгдэнд улам амлалт буй 2023 өмөр, "Түүнэйгэсгэн болго" амьсгаа түүнэй жилдээ айр өрн бөрд ах жаргальн гал манга бардур, амьсэгт бүтээл дүүрэн байгааг өмөн зүүн эц, суурал сайгаа бөхийн хүүсээ.

Урьдчилан  
ЦАГААНУУГИЙН МОНГОЛ  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАГА





## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР


Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн нийт газарт ногдох нөхөн сэргээсэн талбайн эзлэх хувь 2022 онд 16,5 хувь байсан бол 2023 онд 20,5 хувь олгож нэмэгдүүлэхээс 24 хувьд хүргэсэн байна.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2022 онд 22,3 хувь байсныг 23,2 хувьд хүргэж, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ **1732815** га-д хүрлээ.

Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл хаалтын арга хэмжээгээ зохион байгуулж Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг үндэсний болон олон улсын зөвлөхүүд хамтран боловсруулж, хүлээлгэн өгөв.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 4 сумд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд өөрсдийн талбайд 9350 ширхэг мод тарьж ургуулсан.



## ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 239034,408 сая.төгрөгт хүрч, орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 258,8 тонныг үйлдвэрлэж – 10,2 хувийг, “мал төхөөрөх цэг болон бууз баншны үйлдвэр цехэд нийт -502,3 тонн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэж -30 хувийг, сүү, сүүн бүтээгдэхүүн –3,3 мян.л-ийг үйлдвэрлэж -1,4 хувийг, өндөг -78,4 тонныг үйлдвэрлэж, 28 хувийг тус тус хангасан байна. Орон нутгийн үйлдвэрлэлээр нийт 69,6 хувийг хангасан байна.



Хуучин ашиглагдахгүй байсан Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн сургалтын байрыг орон нутгийн 542,6 сая төгрөгийн хөрөнгөөр засварлан "Бизнес хөгжлийн төв" болгон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хүсэлтийн дагуу байраар хангаж, түрээсийн төлбөр төлдөг 20 иргэн, АА нэгжүүдийг урсгал зардлаа төлдөг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлснээр 223,3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.



## АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ - WELCOME TO DUNDGOVI

Аялал жуулчлалын мэдээллийн төвийг шинээр байгуулж, гадаад, дотоодын 1368 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн. Мөн “Дундговь” аялал жуулчлал, бизнес эрхлэлтийг дэмжсэн гар утасны апплекейшн, платформыг хүлээн авч, сурталчлан ажилласан бөгөөд 206 иргэн гар утсандаа татаж суулган ашиглаж байна.



Аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нэвтрэх цэг болон зочид буудал, жуулчны бааз, сувилал, гэр буудал, эвент арга хэмжээний нэгтгэсэн дүнгээр гадаад, дотоодын 79316 жуулчин ирсэн байна. Өмнөх оноос гадаад, дотоодын жуулчид 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

### ТЭЭВЭР, ЛОГИСТИК

2022 оны Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 6338.183 сая төгрөг болж, өмнөх оноос 3038,0 сая төгрөгөөр өссөн байна.





## МЭРГЭШСЭН, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА

2023 онд “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 750,0 сая төгрөгийг батлуулан, нийт 665.1 сая төгрөгийг зарцуулаад байна.



## ТОГТВОРТОЙ, НЭГДМЭЛ ГАДААД БОДЛОГО

БНХАУ, Турк, ОХУ, БНСУ, Япон улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг 2022 онд 700 сая төгрөг байсныг 2023 онд 800 сая.төгрөгт хүргэнэ гэж төлөвлөснөөс нийт 3443,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.



## ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2022 онд 88 хувь байсныг 2023 онд 89 хувь болгохоор төлөвлөж, 89,9 хувьд хүргэсэн байна. Аймгийн хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг 247 байсан бол 2023 онд бүртгэгдсэн гэмт хэрэг 246 байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1 -ээр буурсан үзүүлэлттэй байна.



### Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд

Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, хамгаалах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд ногоон байгууламжийн хэмжээг 2022 онд 381 га-д тариалсныг 2023 онд 392 га болгож нэмэгдүүлэхээр зорилт тавьж, 427 га талбайд ногоон байгууламжтай болсон байна.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговжоо ногооруулъя” хөтөлбөрийн хэрэгжилт 94%-тай хэрэгжсэн бөгөөд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. Улсын төсвөөр 326.0, орон нутгийн төсвөөр 72.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 90.0 сая төгрөг зарцуулж, Нийт 99944 мод, сөөгийг тарьснаас 76.0 хувьтай ургуулсан байна.



Орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд

**БҮС, ОРОН НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ**

Дундговь аймгийн төвд шинээр дулааны станцын ажлыг гүйцэтгэж байна.





“Мандалговь цэцэрлэгт хүрээлэн” байгуулах ажлын төсөвт өртөг 8.8 тэрбум бөгөөд 2023 онд 1,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр санхүүжих 1.6 тэрбум төгрөгийн ажил хийгдэж байна.



### УДААШРАЛТАЙ ХЭРЭГЖИЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

**Хэрэгжилт нь 0-30 хувьтай буюу үр дүнгүй хэрэгжсэн 9 арга хэмжээ байна.**

2.1.1.4 Арга хэмжээ: Өвөр монголын өөртөө засах орны уламжлалтын эмчилгээ, оношилгооны эмч нарын үзлэгийг орон нутагт зохион байгуулах-0%

3.3.3.2 Арга хэмжээ: Дэрэн суман дахь тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж аймгийн тэжээлийн нөөцийн 60-аас доошгүй хувийг үйлдвэрлэх-0%

4.3.1.3 Арга хэмжээ: Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах-0%

6.1.1.7 Арга хэмжээ: Сайнцагаан, Дэрэн, Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах-0%

2.4.4.2 Арга хэмжээ: “Бүрдийн уянга” хүүхдийн зусланд дээвэр, халуун ус, ариун цэврийн шинэ байгууламж, сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах-30%

2.5.1.1 Арга хэмжээ: Төв Халхын Дуулалт Жүжгийн Театрын шинэ барилгын ажлыг үргэлжлүүлэх-30%

3.3.1.3 Арга хэмжээ: “Дундговь үйлдвэрлэл” арга хэмжээг хэрэгжүүлж орон нутгийн онцлогтой брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх хоршоодыг сум бүрд байгуулах-30%

3.6.1.1 Аймгийн төвд ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих томоохон терминал логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах-30%

6.1.1.13 Арга хэмжээ: Дэлгэрхангай уулын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлэх-30% хэрэгжиж байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ


Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөний 6 бодлогын хүрээнд 198 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төсөвлөсөн. Тус үйл ажиллагааны хэрэгжилтийг хянан үнэлээд 93,5% буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

Бодлогын зорилт, салбар, чиглэл	Зорилт	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Үнэлгээ	Зорилт арга хэмжээний дундаж	0%
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО	1	100%	6	100%	100	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	19	95,2%	81	95,1	95.1	1
2.1. Эрүүл мэнд	5	76%	20	95%		1
2.2. Биеийн тамир, спорт	1	100	7	95,7%		
2.3. Боловсрол	3	100%	20	97,1%		
2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	7	100%	20	95%		
2.5 Үндэсний бахархал, өв соёл	3	100%	14	92,8%		
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	9	98%	51	87,1	92.5	1
3.1 Санхүү, төсвийн зохицуулалт	3	100%	8	100%		
3.2 Уул уурхай, хүнд үйлдвэр	1	50	5	82%		
3.3 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	4	75%	24	89,2%		1
3.4 Аялал жуулчлал	1	100%	9	100%		
3.5 Эрчим хүч	1	70%	2	75%		
3.6 Тээвэр, логистик	1	100%	3	76,7%		
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	9	98%	34	96,5	97.2	1
4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ	1	90%	6	100%		
4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба	2	100%	9	100%		
4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм	3	100%	11	82,3%		1
4.4 Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого	1	100%	4	100%		
4.5 Батлан хамгаалах	1	100%	4	100%		
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	6	83,3%	17	95,9%	89.6	
5.1 Ногоон хөгжил	6	83,3%	17	95,9%		
ЗУРГАА. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	2	85%	9	72,2%	78.6	1
6.1 Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжил	2	85%	9	72,2%		1
<b>ЕРӨНХИЙ ДҮН</b>	<b>48</b>	<b>92,6%</b>	<b>198</b>	<b>93.59%</b>		<b>4</b>

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан үр дүнтэй хэрэгжсэн 171 арга хэмжээ, хэрэгжилт хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай 14 арга хэмжээ байна.

№	Агуулга	Зорилтын тоо	Зорилтын биелэлт	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний биелэлт
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	100	6	100
2	Хүний хөгжлийн бодлого	19	95,2	81	95,1
3	Эдийн засгийн бодлого	11	98	51	90,8
4	Засаглалын бодлого	9	98	34	94,3
5	Ногоон хөгжлийн бодлого	6	83,3	17	95,9
6	Орон нутгийн хөгжлийн бодлого	2	85	9	72,2
<b>Дүн</b>		<b>48</b>	<b>92,7</b>	<b>198</b>	<b>93,5</b>

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бодлогын зорилт, арга хэмжээний дунджийг сүүлийн 3 жилээр тооцож дүгнэлт хийж гаргалаа.



Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэхэд нийт 78 тэрбум 962 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгөөр 52499,5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 7383,4 сая төгрөг, хандив тусламжаар 7465,6 сая

төгрөг, гадаадын төсөл болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар 11613,5 зарцуулж хэрэгжүүлсэн байна. Зарцуулсан хөрөнгийг бодлогын хүрээгээр задалж тооцлоо.

	Бодлого	Улсын төсөв	Хандив тусламж	Төсөл хөтөлбөр	Орон нутгийн төсөв	Нийт
1	“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	985.1	366.4	-	-	1351.5
2	Хүний хөгжлийн бодлого	35193.2	495.8	306.0	3452.17	39447.2
3	Эдийн засгийн бодлого	13752.24	1558.1	11079.5	1905.0	28294.8
4	Засаглалын бодлого	78.4	800.0	10.0	1082.3	1970.7
5	Ногоон хөгжлийн бодлого	1490.6	245.3	218.0	301.1	2255.0
6	Орон нутгийн хөгжлийн бодлого	1000.0	4000.0	-	642.8	5642.8
<b>Дүн/ сая.төг/</b>		<b>52499.5</b>	<b>7465.6</b>	<b>11613.5</b>	<b>7383.4</b>	<b>78962.0</b>


**ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД 2023 ОНД ӨМНӨХ ОНООС 12.5 ХУВИАР ИХ ТӨСӨВ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

Агуулга	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Хандив тусламж	Төсөл хөтөлбөр	Нийт дүн
2022 он	53857.9	3583.2	11667.6		69108.7
2023 он	52499.54	7383.37	7465.6	11613.5	78962.01


Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг тооцож, эхний хагас жил, жилийн эцсийн төсөв зарцуулалтад анализ хийж үзэхэд эхний хагас жилд 34343,99 сая төгрөг, сүүлийн хагас жилд 44618,02 сая төгрөг зарцуулж, нийт зарцуулсан хөрөнгийн 43,5 хувийг эхний хагас жилд зарцуулсан байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ															
Бүгд	Дугаар	Агуулга	Төлөвлөсөн санхүүжилт		Эхний хагас жилийн санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэр /сая. төг/					Жилийн эцсийн санхүүжилтийн гүйцэтгэл, эх үүсвэр/ сая. төг/					нэгтгэл
			(сая.төг)	Хөрөнгийн эх үүсвэр	Улсын төсөв	Хандив, зээл, тусламж	Төсөл, хөтөлбөр	Орон нутгийн төсөв	Нийт дүн	Улсын төсөв	Хандив, зээл, тусламж	Төсөл, хөтөлбөр	Орон нутгийн төсөв	Нийт дүн	
<b>1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>															
Зорилго	1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ.													
Зорилт	1.1	Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ.	176.8	УТХО ОНТ	14.5	132.4	0	0	146.9	970.6	234	0	0	1204.6	1351.5
Арга хэмжээ	1.1.1	Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх								56					
	1.1.2	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах	1.8	УТХО	14.5	132.4				321					
				40.0	УТХО										
	1.1.4	Гамшигын үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дэлгэсгээрдүүлэх								7.1					
1.1.5	Цахим шилжилт, туршилтыг ерөнхий	57.5	УТХО						57.5	130					

## ҮР ДҮНГҮЙ БУЮУ 0-30 ХУВЬТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭГ ЧИГЛЭЛЭЭР ХАРУУЛБАЛ:



Үр дүнгүй буюу 0-30 хувьтай хэрэгжиж буй арга хэмжээний шалтгааныг тодруулж судлахад бусад гадаад хүчин зүйлээс шалтгаалсан 5 арга хэмжээ 55,6 хувийг, хөрөнгө санхүүгийн шийдвэрлэгдээгүй, төсөвт батлуулаагүй байдлаас шалтгаалсан 4 арга хэмжээ 44,4 хувийг эзэлж байна.



Удаашралтай хэрэгжиж буй арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор жагсаалт гарган хэлтэс, агентлагийн удирдлага, хариуцсан мэргэжилтнүүдийг байлцуулан сонсгол мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулж, цаашид эрчимжүүлж ажиллах зөвлөмж өгч ажиллалаа.

### 2022 ОНЫ АЖЛЫГ ДҮГНЭЭД ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ХҮРЭЭНД:

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжүүлсэн ба зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлуудыг орон нутгийн иргэдэд уулзалтаар, “Дундговийн амьдрал” сонингоор, <https://www.facebook.com/dundgobi7059106> пэйж хуудсаар болон аймгийн цахим сайт болох <https://dundgovi.gov.mn/>, 15 сум, 24 агентлагийн төрийн байгууллагын сайтаар мэдээлэл өгч сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд АЗДҮАХ-ийн /4.1.1.3-т" Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг улирал бүр зохион байгуулах/ арга хэмжээ төлөвлөн, хэрэгжүүлэх хүрээнд төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, иргэдэд мэдээ мэдээллийг хүртээмжтэй хүргэж, олон нийтийн санал хүсэлтийг сонсон шийдвэрлэх, цаашдын бодлого төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна.

Энэхүү тайланг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 сарын 04-ний 16 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн болно.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад зарим зорилт, арга хэмжээний уялдаа хангагдаагүй, тайлант хугацаанд тухайн оны тоо мэдээлэл гарах боломжгүй статистик үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтээр авсан нь тухайн оны үр дүнг тооцох боломжгүй болох зэрэг зүйлүүд ажиглагдлаа.

Тайланд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программд байршуулан, төлөвлөгөө болон хэрэгжилтийг хэлэлцэж, баталсан тогтоолын хуулбар, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

### **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1. Хэрэгжилтийг [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программд шивэх явцад 2023 оны төлөвлөгөөнд хамаарах 1 арга хэмжээ /2.4.4.5/ орхигдсон, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй 4 арга хэмжээ /2.1.3.1.1, 3.3.1.10, 3.3.3.2, 5.1.1.3/ цахим системд орсон нь тайланг баталгаажуулах боломжгүй болж, хэрэгжилтийг шивэх шаардлагатай болсноор тухайн жилийн үнэлгээнд нөлөөлж байна.

2023 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч программд нэмэгдэж орсон арга хэмжээ 2.1.3.1.1 3.3.1.10 3.3.3.2 5.1.1.3

2. 2023 оны төлөвлөгөөнд орсон боловч программд ороогүй арга хэмжээ 2.4.4.5  
Unelgee.gov.mn цахим программд тайлант оны шалгуур үзүүлэлтийн суурь түвшин нь төлөвлөсөн эхний оноор шивэгдсэн, хүрэх зорилтот түвшин харагдахгүй байгаа нь хэрэгжилтийг шивэхэд, мөн үнэлгээ хийж байгаа албан хаагчдад хүндрэл үүсэж байна.  
Иймээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хавсралтаар баталсан төлөвлөлтийн загвараар программын бүтцийг засаж сайжруулах саналтай байна.

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүдэд:**

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг судлан ажилдаа мөрдөх
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг ойлгомжтой байдлаар, тоо баримттайгаар үр дүнд хүрсэн эсэхийг тодорхой байдлаар баримтжуулан тайлагнах
3. Зарцуулсан төсвийн хэрэгжилтийг тайлагнахдаа сая. төгрөгөөр тоо баримтыг эмх цэгцтэй, эх үүсвэрийг тодорхой, тус тусад нь ялгаж тооцож тайлагнах
4. Арга хэмжээний шалгуурыг хүрэх түвшиндээ хүрсэн эсэхийг тайланд тоон мэдээллээр тусгаж, үр дүнг тайлагнах

5. Удаашралтай, үр дүнгүй хэрэгжиж буй арга хэмжээг хяналтдаа авч, удирдлагуудад танилцуулан, цаашид хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, эрчимжүүлж ажиллах
6. Дараагийн 4 жилийн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахдаа суурь судалгаанд үндэслэн шалгуур үзүүлэлтийг томьёолж, хүрэх түвшнийг зөв тодорхойлж боловсруулах
7. Хугацаа болоогүй байгаа болон 50 хувиас доош хэрэгжилттэй байгаа тасарч болзошгүй буюу 0 хувьтай байгаа зорилт, арга хэмжээг эрчимжүүлж ажиллах талаар харьяа агентлагууддаа чиглэл өгч ажиллах

Цаашид төлөвлөлтийг хийхдээ зорилт, арга хэмжээ 2-ын уялдааг сайн хангах, шалгуур үзүүлэлтийг бодитой зөв томьёолох шаардлагатай байгааг онцолж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС